# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1996 оны 05 дугаар сарын 02 өдөр | Дугаар А/104 | Улаанбаатар хот

Яслиудыг цэцэрлэг-яслийн цогцолбор болгон өргөтгөн зохион байгуулах тухай

1.Монгол улсын Боловсролын хуулийн "сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын тухай" 2,3 дугаар бүлгийн 8, 11 дүгээр зүйл,Шинжлэх ухаан боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 1996 оны 101, А\52 тоот тушаалыг үндэслэн сургуулийн өмнөх боловсролыг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 6, 7, 11, 27, 28, 31, 35, 36 дугаар яслиудыг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн цэцэрлэг-яслийн цогцолбор болгон өргөтгөн зохион байгуулж ажиллуулсугай.

2.Дээрх яслиудын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг шийдвэр гарган акт жагсаалтаар Боловсролын газар \П.Дорж\-т балансаар шилжүүлэхийг Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\-т зөвшөөрсүгэй.

3.Боловсролын газар \П.Дорж\-т даалгах нь:

а\1 дүгээр яслид хамрагдаж байсан хүүхдүүдийг тус тусын дүүргүүдийн цэцэрлэг-яслийн цогцолборт хуваарилан шилжүүлсүгэй.

б\Цэцэрлэг-яслийн цогцолбор болж байгаа яслиудад ажиллаж байгаа өндөр насны тэтгэвэрт гарах болоогүй эрхлэгч нарыг сурган хүмүүжүүлэх дамжаанд суралцуулах, бусад ажилчдыг мэргэшүүлж тухайн цэцэрлэг-яслийн цогцолборуудад ажиллуулсугай.

в\Яслиудыг цэцэрлэг-яслийн цогцолбор болгон өргөтгөн зохион байгуулж байгаатай холбогдуулан хавсралтын дагуу дугаар олгосугай.

г\Цэцэрлэг-яслийн цогцолбор болгон ажиллуулах дээрх яслиудад урьд нь ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүсийг нэг бүрчлэн бүртгэн авч тэдний ахуй амьдралд нь хуулийн хүрээнд боломжоотой байнгын туслалцаа үзүүлж байсугай.

4.Нэгдүгээр яслийн ашиглаж байсан 6 айлын орон сууцыг гачигдалтай иргэдэд Эрүүл мэндийн газрын саналыг харгалзан хуваарилж олгохыг Орон сууц хуваарилалтын тасаг \С.Баатарсүрэн\-т зөвшөөрсүгэй.

5.Нийслэлийн ясли, цэцэрлэгүүдийн 1996 оны сүүлийн хагас жилийн төсөвт зохицуулалт хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтэс \Д.Гонгор\, Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\, Боловсролын газар \П.Дорж\, дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

6.Цэцэрлэг-яслийн цогцолборын орон тоог зохицуулан мэргэжлийн удирдлага, багшаар хангах, хяналт тавьж ажиллахыг Боловсролын газар \П.Дорж\, Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\, дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7.Эрүүл мэндийн газар \Г.Буян-Өлзий\-т даалгах нь:

а\Хүн чадлаа бүрэн ажиллаж чадахгүй байгаа, зориулалтын бус байртай 1 дүгээр яслийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн энэ оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн татан буулгаж устгалын тайлан баланс гаргаж эмч хөрөнгийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэсүгэй.

б\1 дүгээр яслиас орон тоогоор чөлөөлөгдөх тэтгэврийн бус насны ажилтнуудыг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад зохицуулан ажиллуулах буюу Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу холбогдох дүүргүүдийн хөдөлмөр зохицуулах албанд шилжүүлсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Ц.БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1996 оны А/184 тоот захирамжийн хавсралт

ЯСЛИУДЫГ ЦЭЦЭРЛЭГ-ЯСЛИЙН ЦОГЦОЛБОР БОЛГОН ӨРГӨТГӨН ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН СОЛИХ ДУГААР

| ЯСЛИЙН ДУГААР | ШИНЭЭР ОЛГОСОН ДУГААР |
|---|---|
| 1. 6 дугаар ясли | 146 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 2. 7 дугаар ясли | 152 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 3. 11 дугаар ясли | 38 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 4. 27 дугаар ясли | 143 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 5. 31 дугаар ясли | 33 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 6. 28 дугаар ясли | 4 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 7. 35 дугаар ясли | 149 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |
| 8. 36 дугаар ясли | 150 дугаар цэцэрлэг яслийн цогцолбор |